

**ТӨРӨӨС ТЭТГЭВРИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО  
БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ  
ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 04 дүгээр  
сарын 07-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2015 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого нь хүн амын насын бүтцийн тааламжтай үед тэтгэврийн тогтолцоог шинэчилж, олон давхартгат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, ахмад настанд тэтгэврийг урт хугацаанд тогтвортой олгох нөхцөлийг бүрдүүлэх, тэтгэврийн даатгалд малчид, албан бус салбарт ажиллагсдыг бүрэн хамруулж, хамрах хүрээг өргөтгөх, тэтгэврийн сангийн алдагдлыг бууруулах, тэтгэврийн даатгалын шимтгэл, тэтгэврийн нас, тэтгэвэр бodoх аргачлалыг оновчтой тогтоох, нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэгдсэн байна.

Уг төслийг хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн А.Тлейхан тэтгэврийн зөрүүг арилгахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, тэтгэврийн шимтгэлийн хувь хэмжээ болон тэтгэврийн насыг нэмэгдүүлэх нь хэр оновчтой болох, Улсын Их Хурлын гишүүн Г.Оюунгэрэл олон давхартгат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, суурь тэтгэвэртэй болох, Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нийгмийн даатгалын сангийн менежментийг сайжруулах, мөнгөжүүлэх, шимтгэлд суурилсан тэтгэврийн тогтолцоонд шилжих, нийгмийн даатгалын шимтгэлээ төлсөн иргэдийг урамшуулах зэрэг санал гаргав.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн З.Баянсэлэнгэ тэтгэврийн зээлийн хүүг бууруулах, тэтгэврийн зээлтэй холбоотой асуудлыг тусгах, Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр энэ асуудлыг хэлэлцэх нь цаг үеэ олсон эсэх, Улсын Их Хурлын гишүүн А.Бакей бодлого, хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах, тэдгээрийн хөрөнгийн эх үүсвэр, хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, тэтгэврийн даатгалын харилцааг зах зээлийн зарчимд нийцүүлэх нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дээрх тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа..

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**

**Д.БАТЦОГТ**

